



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/708

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Аймгийн Цагдаагийн газраас зохион байгуулж буй мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хяналтын 11 цэгт үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдын хоолны зардалд 6600.0 мянган төгрөг/Зургаан сая зургаан зуун/-ийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Тус арга хэмжээний 6600.0 мянган төгрөг /Зургаан сая зургаан зуун/-ийг аймгийн Засаг дарга дансны зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2020 оны  
11 дүгээр сарын 17-ны өдрийн  
А/708 дугаар захирамжийн хавсралт



АЛБАН ХААГЧДЫН ХООЛНЫ ЗАРДАЛ

Д/Д	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Хоол	Хүн/өдөр	22/30	10000	6 600 000
Нийт					6 600 000

-oOo-